



НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/24

Улаанбаатар хот

「 Хаврын ээлжит техникийн хяналтын үзлэг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Автотээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 213 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/536 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм”-ийн 4.1.2.5, 7.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний их, дунд багтаамжийн автобус, ажилчдын автобус болон таксийн тээврийн хэрэгслүүдийн хаврын ээлжит техникийн хяналтын үзлэгийг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 22-ний өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулах хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Уг үйл ажиллагааг Автотээврийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад нийцүүлэн шуурхай зохион байгуулж, тээврийн хэрэгслүүдийг хуваарьт хугацаанд, холбогдох стандартын шаардлагуудыг бүрэн хангуулж, үзлэгт хамрагдаагүй болон тэнцээгүй тээврийн хэрэгслүүдийн мэдээллийг Tbox.uscc.mn программ хангамжид тухай бүрд нь оруулж, тэнцээгүй тээврийн хэрэгслийг тухайн өдөрт нь давтан оруулахгүй байх, техникийн хяналтын үзлэгийн дүн мэдээг удирдлагад тайлагнаж холбогдох хэлтсүүдийг мэдээллээр шуурхай хангаж ажиллахыг Бүртгэл техник, технологийн хэлтэс (М.Мөнхбаяр)-т даалгасугай.

3. Нийтийн тээврийн үйлчилгээний бүртгэлийн санд бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдэд холбогдох стандартын шаардлагуудыг бүрэн хангуулж, тээврийн хэрэгслийн өнгө үзэмж, цэвэрлэгээ, иж бүрдэл, замналын нэр, хаяг, зураглал, гарааш дугаар зэрэг нэмэлт шаардлагуудын хэрэгжилт хангагдсан эсэхэд онцгой анхаарч тушаалаар батлагдсан хуваарьт хугацаанд багтаан хаврын ээлжит техникийн хяналтын үзлэгт жигд, шуурхай хамруулахыг нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.БИЛГҮҮН

